



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын харьяа зарим Татварын хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 223,764,297.00 (хоёр зуун хорин гурван сая долоон зуун жаран дөрвөн мянга хоёр зуун ерэн долоон) төгрөгийн балансын үнэ, 91,862,780.54 (ерэн нэгэн сая найман зуун жаран хоёр мянга долоон зуун наян төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.Таван

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002207

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн
388 дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа зарим Татварын хэлтсүүдийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй аctalж, данснаас хасах барилгын жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Конторын барилга	1989	Өмнеговь, Даланзадгад сум, 4 дүгээр баг, тоосгон ханатай, төмөр бетон хавтан хучилттай, 1 давхар (Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчын 2013 оны 16/07/51/230, 2013 оны 16/07/46/190 дүгээр дүгнэлт)	200,796,033.00	84,516,184.14	116,279,848.86
2	Тоосгон суурьтай төмөр хашаа	1986	Өмнеговь, Даланзадгад сум, 4 дүгээр баг, төмөр хашаа 50м	850,230.00	850,230.00	0
3	Машины зогсоол /хувьчлагдсан орон сууцны/	1996	Булган аймаг, Булган сум, 5 дугаар баг, 186 байрны хойд талын зогсоол	3,805,000.00	3,805,000.00	0
4	Конторын барилга	1959	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, 1 давхар, чулуун ханатай, аж ахуйн аргаар барьсан, (Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчын 2010 оны 50-07/56, 2012 оны 23-07-028/401 дүгээр дүгнэлт)	18,313,034.00	2,691,366.40	15,621,667.60
	Нийт дүн			223,764,297.00 (хоёр зуун хорин гурван сая долоон зуун жаран дөрвөн мянга хоёр зуун ерэн долоон)	91,862,780.54 (ерэн нэгэн сая найман зуун жаран хоёр мянга долоон зуун наян төгрөг тавин дөрвөн мөнгө)	131,901,516.46 (нэг зуун гучин нэгэн сая есөн зуун нэг мянга таван зуун арван зургаан төгрөг дөчин зургаан мөнгө)